



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 01 өдөр

Дугаар А/627

Булган сум

Гүйцэтгэгчтэй гэрээ шууд байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалт, Засгийн газрын 2021 оны “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 124 дүгээр тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 108 дугаар тушаалаар батлагдсан “Зураг төслийн жишиг үнийн дүрэм” БД81-16-20, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XVII/01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын “Б, В” блокийн дээврийн их засварын ажлын зураг төслийг 19,000,000 (арван есөн сая) төгрөгөөр “Өрх” ХХК-тай шууд гэрээ байгуулах эрхийг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т олгосугай.

2. Гэрээнд заагдсан ажлыг тогтоосон хугацаанд чанартай гүйцэтгэн, экспертизээр батлуулан хүлээлгэн өгөхийг “Өрх” ХХК (А.Бат-Од)-д үүрэг болгосугай.

3. Аймгийн Засаг даргын Тамгын газрын “Б, В” блокийн дээврийн их засварын ажлын зураг төсөв боловсруулах явцад хяналт тавьж хүлээн авахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

4. Аймгийн Засаг даргын Тамгын газрын “Б, В” блокийн дээврийн их засварын зураг төсөв боловсруулах ажлын гэрээнд заагдсан санхүүжилтийг 2023 оны орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхийг Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Батцогт)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



БАРИУН-ЭРДЭНЭ